



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/41

Улаанбаатар хот

"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын
данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/61 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ашиглалтын шаардлага хангахгүй болж, засаж сэлбэх нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн 644,499,900 (зургаан зуун дөчин дөрвөн сая дөрвөн зуун ерөн есөн мянга есөн зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан тээврийн хэрэгслүүдийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ (О.Ганбаатар)-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслүүдийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслүүдийн гэрчилгээ, улсын дугаарыг хураан авч, авто тээврийн улсын бүртгэл болон татварын бүртгэлээс хасуулахыг "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ (О.Ганбаатар)-т үүрэг болгосугай.

3.Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (Б.Батбаяр)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

ДАРГА  М. БАЯРАА





Нийслэлийн Өмчийн Харилцааны газрын даргын
2022 оны 02 сарын 19 -ны өдрийн
... А/... тушаалын хавсралт

СЭЛБЭГИЙН БУЮУ ХОЁРДОГЧ ТҮҮХИЙ ЭДИЙН ЗОРИУЛАЛТААР ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЖ
ХУДАЛДАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

д/д	Байгууллагын нэр	Автомашини марк, улсын дугаар	Үйлдвэрлэсэн Монголд ашиглаж эхэлсэн он	Зориулалт, аль улсад үйлдвэрлэсэн, өнгө	Арлын дугаар	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Эвдрэл гэмтэл
1	"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ	Хьюндай каунти 86-32 УБН	2015/2015	Суудал БНСУ Цэнхэр	КВJHG17PPFC067334	558164	128,899,980	Явах эд анги элэгдсэн, урд тэнхлэг эвдэрсэн, хөдөлгүүрийн түлш, маслын зарцуулалт ихэссэн, хурдны хайрцаг, тоормосны систем, жолооны механизмын сул явалт зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрч жолоодлого хийхэд хүндрэлтэй болж ашиглалтын шаардлага хангахгүй болсон
2		Хьюндай каунти 16-81 УБН	2015/2015	Суудал БНСУ Цэнхэр	КВJHG17PPFC067314	604731	128,899,980	
3		Хьюндай каунти 49-17 УБН	2015/2015	Суудал БНСУ Цэнхэр	КВJHG17PPFC067318	544108	128,899,980	
4		Хьюндай каунти 12-61 УБН	2015/2015	Суудал БНСУ Цэнхэр	КВJHG17PPFC067311	548494	128,899,980	
5		Хьюндай каунти 16-01 УБН	2015/2015	Суудал БНСУ Цэнхэр	КВJHG17PPFC067312	323426	128,899,980	
Нийт							644,499,900	